

## ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОН ЗАХИРГААНЫ ХЭМ ХЭМЖЭЭНИЙ АКТЫН ТӨСӨЛ, ТАНИЛЦУУЛГА, СУДАЛГАА

Аймгийн Засаг даргын захирамжаар “Монгол Улсын Үндсэн хууль батлагдсаны 29 жилийн ой”-г тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд аймгийн хэмжээнд сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулж, Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг иргэд олон нийтэд сурталчиллаа. Мөн тус өдрийг тохиолдуулан аймгийн Засаг даргын 2021 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн “Хүндэтгэл үзүүлэх тухай” А/13 дугаартай захирамжаар Монгол Улсын Үндсэн хууль батлалцсан Ардын Их Хурлын депутатууд болон ар гэрт нь хүндэтгэл үзүүллээ. “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтыг аймгийн Гаалийн газрын 40 гаруй Улсын байцаагч нарт цахим хэлбэрээр Хөгжлийн шийдэл ТББ-тай хамтран зохион байгууллаа. Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох салбарын хууль тогтоомжийнтөсөлд тусгах саналыг аймгийн хэмжээнд авч нэгтгэн Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт тус тус хүргүүлсэн. Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн албаны зөвлөл, Удирдлагын академитай хамтран 2022 оны 01 сарын 1-ээс хэрэгжих хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/-аар 11 удаа, МУЗЗНДНТУТХ-ын шинэчилсэн найруулгаар 8 удаагийн сургалт сурталчилгааг цахим болон танхимаар зохион байгуулж, гарын авлага материал тараан 1983 иргэн, аймгийн Төрийн албаны Зөвлөлийн Салбар зөвлөлийн гишүүд, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нар болон аймаг, сумдын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, албадын холбогдох мэргэжилтэн, албан хаагчдыг хамруулан ажиллалаа.

Шаамар, Сант, Ерөө, Цагааннуур, Хушаат, Түшиг, Орхонтуул, Алтанбулаг, Баруунбүрэн, Жавхлант сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон тогтоолуудыг “Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэл”-д бүртгүүлсэн. Улсын нэгдсэн санд бүртгэлтэй аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 28, аймгийн Засаг даргын 2 захиргааны хэм хэмжээний акт байгаа бөгөөд одоогоор нэмэлт, өөрчлөлт хийгдээгүй хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэлтэй актын тулгалт судалгааг хийж Хууль зүй, дотоод хэргийн яамны Захиргааны хэм хэмжээний актын хяналт бүртгэлийн хэлтэст аймгийн Засаг даргын албан тоотоор хүргүүлсэн. Аймгийн Засаг даргын 2023 оны “Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх цагийн хязгаарийг шинэчлэн тогтоох тухай” А/02 дугаартай захиргааны хам хэмжээ тогтоосон захирамжаар аймгийн хэмжээнд 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлэн согтууруулах ундаа худалдах цагийн хязгаарыг 10.00-00.00 цаг, үйлчлэх цагийн хязгаарыг 11.00-04.00 цаг хүртэл байхаар тогтоож Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүллээ. Газрын тухай, Газрын төлбөрийн тухай хуульд тус тус өөрчлөлт орсонтой

холбогдуулан “Газрын үнэлгээний бүсчлэл, газрын төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төслийг бэлтгэн иргэдээс санал авах ажлыг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргаас 2022 оны жилийн эцсийн байдлаар 577 захирамж, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 232 тушаалын хууль, эрх зүйн үндэслэлийг төсөл тус бүрээр хянаж, захирамжийн дагалдах хуудсанд санал дүгнэлтийг тухай бүр өгч, захиргааны шийдвэрийн хувийн хэргийг хөтлүүлэн Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилтийг ханган ажилласан.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас “Хүүхэд хамгаалал” цахим хурлыг 2022 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр 17 сумын Засаг дарга, 6 тосгоны захирагч, хамтарсан багийн гишүүд, Ерөнхий боловсролын сургуулийн захирлууд, сургууль, цэцэрлэгийн эцэг, эхийн зөвлөлийн төлөөлөл болон алба хаагчдыг оролцуулан зохион байгуулж, Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Боловсролын газар, Онцгой байдлын газар, Стандарт хэмжил зүйн үндэсний төвийн холбогдох мэргэжилтнүүд хүүхдийг гэмт хэрэг, зөрчил аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч, тэдний санал хүсэлтийг сонсож ажилласан.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх болон гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагааннуур, Зүүнбүрэн, Шаамар, Түшиг сумын малчин, мал бүхий иргэдтэй 2022 оны 01 дүгээр сард малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж мал бүхий 315 малчин иргэдийг хамруулж, иргэдийн санал хүсэлтийг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэсэн.

**ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ХЭЛТЭС.**